



Diversity & Inclusion

Олон талт ялгаатай байдал ба оролцоо

Ажлын байранд олон талт ялгаатай байдлыг чөлөөтэй дэмжсэнээр аливаа гарсан асуудал хурдан шийдвэрлэгдэх, шийдвэр гаргалт сайжрах, инновац дэмжигдэх, ажилтны энгэйжмент сайжрах мөн санхүүгийн гүйцэтгэлд ч эерэг нөлөө үзүүлэх ашиг тустай байдаг. Хэдий тийм боловч олон талт ялгаатай байдал нь жинхэнээсээ хүн бүрийн оролцоо бүхий орчин нөхцөл оршин тогтносон үед л бүрэн гүйцэд ашиг тусаа гаргадаг. Олон төрлийн авьяаслаг ажилтнууддаа үнэ цэнтэй гэдгийг нь байгууллагын соёл нь мэдрүүлж чадаагүй бол тэр байгууллага үнэ цэнтэй ажилтнуудаа алдах нь ойлгомжтой.

Дэйл Карнегийн энэхүү цоо шинэ хөтөлбөр нь байгууллагын хүрээнд хүртээмжтэй байдал, тэгш байдлыг хангахад саад болж буй далд хэвшмэл ойлголтуудыг олж илрүүлэхэд танд тусална.

ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОНООР ТА ДАРААХ ЧАДВАРУУДЫГ ЭЗЭМШИНЭ:

- Байгууллагын болон хувь хүний гарал үүсэл, соёлыг таних чадвараа сайжруулж өмнөхөөсөө илүү соёлтойгоор харилцах.
- Ухамсартайгаар эсвэл ухамсаргүйгээр үүсдэг өрөөсгөл хандлагаа таньж мэдэх. Өрөөсгөл хандлагаас болж бусад хүмүүст болон хамтран ажилладаг байгууллагуудад үзүүлдэг сөрөг нөлөөллийг аль болох багасгах.
- Өөрийнхөө болон байгууллага, хамт олныхоо төлөө өөрийн зарчим, итгэл үнэмшил, зорилгод үнэнчээр дүн шинжилгээ хийж өөртөө итгэх итгэлээ нэмэгдүүлэх. Сөрөг санал хүсэлт ирсэн тохиолдолд эергээр хүлээн авч, засаж залруулахад анхаарлаа төвлөрүүлэх.
- Харилцагчаа чин сэтгэлээсээ ойлгож, зөрчилдөөнийг үр дүнтэй зохицуулах, үл ойлголцол бий болохоос урьдчилан сэргийлэх, итгэлцэл бүтээж, сэтгэл зүйн хувьд аюулгүй нөхцөл байдлыг бий болгох, мөн хүчирхэг харилцааг бүтээх ур чадварыг хөгжүүлэх.

Сургалтын дэлгэрэнгүй агуулга	Сургалтад оролцсоноор та дараах чадваруудыг эзэмших болно:
Итгэлцэл бүтээх, Сэтгэл зүйн аюулгүй байдлыг бий болгох	<ul style="list-style-type: none"> • Итгэлцэл, хүлээн зөвшөөрөл, хүндлэл хоорондын хамаарлыг ойлгох • Итгэл алдрах байдлыг бууруулж, эвдэрсэн итгэлийг сэргээх • Итгэлцэлд суурилсан орчныг төлөвшүүлэх зарчмуудыг хэрэгжүүлэх • Өөрийнхөө эргэн тойронд сэтгэл зүйн аюулгүй байдлыг үүсгэх
Соёлыг таньж мэдэх чадвар	<ul style="list-style-type: none"> • Ухамсартай болон ухамсаргүйгээр үүсдэг өрөөсгөл хандлагыг ойлгох • Ялгаатай байдлыг багасгахын тулд батлагдсан арга хэрэгслүүдийг ашиглах • Бичил түрэмгийллийн нийтлэг тохиолдлын талаар олж мэдэх
Олон талт ялгаатай байдлын үнэ цэн	<ul style="list-style-type: none"> • Олон талт ялгаатай байдалд үнэт зүйлс ямар үүрэгтэй байдаг талаар олж мэднэ. • Бусад соёлыг гүнээ хүндэтгэхийн чухлыг олж мэднэ. • Нуугдмал өрөөсгөл хандлагаас сэрэмжлэх талаар олж мэднэ.
Соёл хооронд холбогдож харилцах	<ul style="list-style-type: none"> • Соёлын ялгаатай байдлын хооронд холбогч гүүр байгуулахын тулд түүх ярих урлагт суралцах • Сонсогчдод нөлөөлөхийн тулд түүх ярихдаа сэтгэл хөдлөлийг бий болгох • Бусдыг ойлгож сонсох чадварыг бий болгох • Өөрийн туршлага, мэдлэгийг ашиглан илүү өөртөө итгэлтэйгээр харилцаж, өмнөх амьдралын туршлага маань зан төлөвт хэрхэн нөлөөлж байгааг олж мэдэх.
Өөрийгөө таньж мэдэх чадвараа нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none"> • Хэтийн зорилго болон өөрийгөө таньж мэдэх чадвар хоёрын хоорондох хамаарлыг тайлбарлана. • Өөрийгөө таньж мэдсэнээр олон төрлийн баг хамт олныг үр дүнтэй удирдах чадварт тань эерэг нөлөө үзүүлж болохыг олж тодорхойлно. • Өөрийн үнэт зүйлс, хүсэл эрмэлзэл, сэтгэлгээний хэв маяг, хандлага, сэтгэл хөдлөлийн хариу үйлдэл, давуу болон сул талууд, тэдгээрийн бусдад үзүүлэх нөлөөний талаар илүү үнэн зөв ойлголттой болно
Зөрчилдөөний стратеги	<ul style="list-style-type: none"> • Зөрчилдөөний эх үүсвэрийг тодорхойлох • Зөрчилдөөнд гаргаж буй хариу үйлдэлдээ дүн шинжилгээ хийх • Зөрчилдөөнтэй нөхцөл байдалд боломжуудыг бий болгох • Нуугдмал зөрчилдөөнийг ил гаргах • Дургүйцэл, зэвүүцэлгүйгээр зөрчилдөөнийг шийдэх
Нийтлэг үндэслэлээ олох	<ul style="list-style-type: none"> • Нээлттэй, илэн далангүй харилцахын тулд үзэл бодлоо илэрхийлэхдээ итгэлтэй, тууштай байх. • Хувийн асуудлын сэдэв болон зөрөлдөж байх үеийн үүрэг хариуцлагаа тодорхойлох. • Эргэлзэхийн ашиг тусыг бусдад мэдрүүлж, санал бодлыг нь ойлгож байгаагаа зөөлрүүлэн илэрхийлэх. • Санал гаргах, санал нийлэхгүй байх томъёог тохиромжтой байдлаар хэрэглэх. • Нийтлэг үндэслэлээр гүүр барих
Өөрчлөлтөд нөлөөлж, тогтвортой байлгах	<ul style="list-style-type: none"> • Бусад хүмүүс, бид нар ч өөрсдөө ялгаагүй өөрчлөлтөд янз бүрийн байдлаар хариу үзүүлдэг гэдгийг олж мэднэ. • Соёлын өөрчлөлтийн үед үлгэр дуурайлал авч, өөрсдийгөө удирдах арга замаа тодорхойлно. • Ойлголтоо баталгаажуулж, урам зоригтой байж, өөрийгөө таних чадвараа үргэлжлүүлэн хөгжүүлнэ. • Эерэг дүгнэлтийг бусдад хэлж, мөн бусдаас хүлээн авах чадвараа хөгжүүлнэ.